



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ



Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.7%, 2020 онд: +6.1%  
Инфляци: 2019 онд: +8.5%, 2020 онд: 7.5%

Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий -9.6%, 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.3%  
Инфляци: 2019 онд: +7.1%,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: -10.8%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 9-р сарын байдлаар 484 тэрбум төгрөгийн ашигтай гарав.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 18.9 хувиар, зарлага 15.7 хувиар тус тус нэмэгдсэн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 484 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 242 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.



**Ам.долларын ханш өмнөх сараас 0.8 төгрөгөөр буурав.**

Есдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 166 төгрөг буюу 6.6 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 0.8 төгрөг буюу 0.03 хувиар буурч 2669.68 төгрөг болов. 9-р сард гадаад валютын нөөц 3.9 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 8 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 37.7 хувиар тус тус өсчээ.



**Инфляцийн түвшин 9%**


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 9-р сарын байдлаар өмнөх сараас 0.1 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар, оны эхнээс 5.4 хувь өсөв. Өмнөх сараас өөрчлөлтгүй гарахад

хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ буурсан ч орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ, согтууруулах ундаа, тамхины үнийн дүн өссөн нь нөлөөлөв.



**Гадаад худалдааны тэнцэл 1347 сая.ам доллар болов.**

2019 оны есдүгээр сард нийт барааны эргэлт 10545 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 12.5, импорт өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 1347 сая ам.долларын ашигтай гарчээ.



## 9-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ



Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 9-р сард өмнөх сараас 0.6 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 11.1 хувиар нэмэгдэж 18.1 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1973 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 3.1 хувиар нэмэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 45.1 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 10.8% байна.

## САРЫН ОНЦЛОХ (МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨР ДНБ-ИЙ 224 ХУВЬТАЙ ТЭНЦЭЖ БАЙНА.)

**ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ 2019 ОНД АШИГТАЙ, 2020 ОНД АЛДАГДАЛТАЙ БАЙХ ТӨСӨӨЛӨЛ БАЙНА**

- Монголбанкны Мөнгөний бодлогын газраас "Нэрлэсэн ДНБ-ийг 2020 онд 41.1 их наяд төгрөг байхаар төсөөлж байна. Эдийн засгийн өсөлт буюу бодит ДНБ-ийг 5.1-6.3 хувьтай байхаар авч үзлээ. Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэж байгаа инфляц 2019 оны эцэст 8 хувь, 2020 оны дөрөвдүгээр улиралд 7.2 хувьтай байх төлөв ажиглагдаж байна. Эдийн засгийн өсөлт энэ жилийн хувьд 7 хувь байх төсөөлөлтэй байна. Төлбөрийн тэнцэл энэ жил ДНБ-ий 2.6 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай байхаар ирэх жил 3.2 хувьтай тэнцэх хэмжээнд алдагдалтай байхаар төсөөлж байна. Төсвийн орлого ба тусламжийн дүн ирэх онд ДНБ-ий 29.6 хувьтай, нийт зардал ба цэвэр зээлийн дүн 32.1 хувьтай тэнцэх тооцоо гарсан" гэв. Эдгээр тооцоо судалгаанд Засгийн газраас өргөн барьсан төсөвтэй холбоотой өөрчлөлт орж болзошгүй байна.

**МОНГОЛ УЛС ИРЭХ ДӨРВӨН ЖИЛД 14 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ГАДААД ӨР ТӨЛНӨ**

- Нүүрсний хилийн үнэ энэ онд 74 орчим ам.доллар, ирэх жил 67 ам.доллар, зэсийн үнэ 6000 ам.доллар, алтны энэ жилийн дундаж үнэ энэ онд 1350, ирэх онд 1410 ам.доллар, нефтийн үнэ 64 орчим ам.доллар байх төсөөлөл гарчээ. Төмрийн хүдрийн үнэ 82 орчим ам.доллар байсан нь ирэх жил 73 ам.доллар болж буурна. Монгол Улсын гадаад өрийн хэмжээ нэрлэсэн дүнгээр 29.5 тэрбум ам.доллар байгаа нь ДНБ-ий 224 орчим хувьтай, экспортын орлогын 430 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн байна. Үүнээс Засгийн газрын өр хоёр орчим тэрбум ам.доллар байна. Нийт өрийн тал хувийг буюу 14 тэрбум ам.долларыг 2020-2024 онд эргүүлж төлнө. 14 тэрбум ам.доллар нь өнөөгийн манай гадаад валютын нөөцийг гурав нэмэгдүүлсэнтэй тэнцэнэ. Засгийн газар эдгээр өр төлбөрийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг багасгах үүднээс дахин санхүүжилттэй хослуулан төлөх стратегийг баримталж байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 9-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 9-р сар 2019 он, Монголбанк
- [www.1212.mn](http://www.1212.mn), [www.monqolbank.mn](http://www.monqolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)